

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/31/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯННУУР СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.ЗАНГАР ТАНАА

2022.02.25 № 180
танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,938,643.48	4,110,575.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	120,000.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	120,000.00	-
3122	Гадаад валют	120,000.00	-
31223	Арилжааны банк дахь харилцах	120,000.00	-
33	АВЛАГА	880,713.48	2,098,745.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	499,970.00	2,098,745.00
335	Бусад авлага	380,743.48	-
3351	Байгууллагаас авах авлага	380,743.48	-
35	БАРАА МАТЕРИАЛ	937,930.00	2,011,830.00
354	Хангамжийн материал	187,930.00	1,261,830.00
35410	Бичиг хэргийн материал	121,730.00	121,730.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,073,900.00
35440	Түлш, шатах тослох материал	66,200.00	66,200.00
35600	Мал амьтад	750,000.00	750,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	620,507,574.53	636,309,184.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	620,507,574.53	636,309,184.77
392	Биет хөрөнгө	598,111,574.53	613,913,184.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	499,989,260.00	499,989,260.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(53,029,546.15)	(70,453,254.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	160,019,850.00	155,305,640.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(113,212,017.26)	(119,453,211.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	231,984,088.00	251,168,588.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(178,585,238.52)	(180,694,252.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,039,042.00	27,387,130.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,494,901.08)	(24,036,919.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	165,430,520.00	196,174,020.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(118,313,482.46)	(121,757,815.79)
39217	Ном	284,000.00	284,000.00
393	Биет бус хөрөнгө	22,396,000.00	22,396,000.00
39301	Програм хангамж	549,300.00	549,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(549,300.00)	(549,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,396,000.00	22,396,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	622,446,218.01	640,419,759.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,800,363.00	2,284,798.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,800,363.00	2,284,798.00
413	Өглөг	11,800,363.00	2,284,798.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,718,428.00	2,284,798.00
4136	Бусад өглөг	1,081,935.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,081,935.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	610,645,855.01	638,134,961.77

51	Засгийн газрын хувь оролцоо	610,645,855.01	638,134,961.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	409,753,076.00	409,753,076.00
51101	Өмч: - төрийн	409,753,076.00	409,753,076.00
512	Хуримтлагдсан үр дүн	13,900,689.23	56,054,005.99
51210	Өмнөх үеийн үр дүн	13,900,689.23	28,564,899.23
51220	Тайлант үеийн үр дүн	-	27,489,106.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	186,992,089.78	172,327,879.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	622,446,218.01	640,419,759.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	469,307,160.00	371,214,380.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	172,272,770.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	172,272,770.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	172,152,770.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	172,152,770.00	-
120009	Бусад орлого	120,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	297,034,390.00	371,214,380.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,367,822.00	1,538,580.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,367,822.00	1,538,580.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	289,666,568.00	369,675,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289,666,568.00	316,091,300.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	-	53,584,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	322,941,559.29	343,725,273.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	322,941,559.29	343,725,273.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,808,720.29	331,302,073.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	219,912,446.00	215,080,034.15
210101	Үндсэн цалин	219,912,446.00	141,778,750.76
210102	Нэмэгдэл	-	63,915,291.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,185,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	8,200,592.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,962,909.52	26,563,004.33
210201	Тэтгэврийн даатгал	27,962,909.52	18,281,803.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,150,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,720,640.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	430,160.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	3,979,601.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,847,800.00	18,322,400.00
210301	Гэрэл, цахилгаан	993,000.00	1,164,800.00
210302	Түлш, халаалт	18,854,800.00	17,157,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,467,803.00	12,758,265.00
210401	Бичиг хэрэг	2,155,670.00	2,008,900.00
210402	Тээвэр, шатахуун	13,380,233.00	9,453,865.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	931,900.00	1,224,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	70,800.00

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	51,600.00	3,954,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	3,612,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	51,600.00	342,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	216,700.00	2,389,800.00
210604	Урсгал засвар	216,700.00	2,389,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,037,800.00	2,739,800.00
210702	Дотоод албан томилолт	1,037,800.00	2,739,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,383,300.00	1,264,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,500.00	112,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	47,900.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	178,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	458,100.00	398,700.00
210807	Газрын төлбөр	-	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	92,200.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,928,361.77	48,229,669.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,904,062.00	3,923,580.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	499,950.00	229,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,524,349.77	44,076,389.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,132,839.00	12,423,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	12,423,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	12,423,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,132,839.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,132,839.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	146,365,600.71	27,489,106.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	146,365,600.71	27,489,106.76

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	409,753,076.00	186,992,089.78	13,900,689.23	0.00	610,645,855.01
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	409,753,076.00	186,992,089.78	13,900,689.23	0.00	610,645,855.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			14,664,210.00		14,664,210.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	409,753,076.00	186,992,089.78	28,564,899.23	0.00	625,310,065.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		-14,664,210.00			-14,664,210.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			27,489,106.76		27,489,106.76
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	409,753,076.00	172,327,879.78	56,054,005.99	0.00	638,134,961.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	297,154,390.00	317,629,880.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	120,000.00	-
120009	Бусад орлого	120,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	297,034,390.00	317,629,880.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,367,822.00	1,538,580.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,367,822.00	1,538,580.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	289,666,568.00	316,091,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289,666,568.00	316,091,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	297,034,390.00	311,456,380.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	297,034,390.00	311,456,380.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,901,551.00	299,033,180.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,317,641.00	221,406,300.00
210101	Үндсэн цалин	148,235,000.00	148,105,016.61
210102	Нэмэгдэл	48,765,023.00	63,915,291.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт		1,185,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,317,618.00	8,200,592.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,650,200.00	29,888,400.00
210201	Тэтгэврийн даатгал	20,865,000.00	21,032,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,196,200.00	2,214,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,757,000.00	1,771,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	439,300.00	442,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,392,700.00	4,428,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,848,000.00	18,322,400.00
210301	Гэрэл, цахилгаан	993,000.00	1,164,800.00
210302	Түлш, халаалт	18,855,000.00	17,157,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,159,030.00	8,649,300.00
210401	Бичиг хэрэг	2,178,470.00	2,248,400.00
210402	Тээвэр, шатахуун	13,048,660.00	5,088,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	931,900.00	1,224,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		88,000.00
2105	Нормативт зардал	51,600.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	51,600.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,216,700.00	2,408,600.00
210604	Урсгал засвар	2,216,700.00	2,408,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,871,068.00	2,739,800.00
210702	Дотоод албан томилолт	1,871,068.00	2,739,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,383,300.00	1,302,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,500.00	150,400.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	47,900.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	178,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	458,100.00	398,700.00
210807	Газрын төлбөр	-	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	92,200.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,404,012.00	13,858,580.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,904,062.00	13,358,580.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	499,950.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,132,839.00	12,423,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	12,423,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		12,423,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,132,839.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,132,839.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	120,000.00	6,173,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	6,293,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	6,293,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	6,293,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		6,293,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(6,293,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	120,000.00	(120,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		120,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	120,000.00	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		120,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	316,091,300.00	316,091,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	316,091,300.00	316,091,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	303,668,100.00	303,668,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,406,300.00	221,406,300.00
210101	Үндсэн цалин	161,145,000.00	148,105,016.61
210102	Нэмэгдэл	46,036,400.00	63,915,291.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,185,400.00	1,185,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,039,500.00	8,200,592.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,888,400.00	29,888,400.00
210201	Тэтгэврийн даатгал	21,032,300.00	21,032,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,214,000.00	2,214,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,771,200.00	1,771,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	442,800.00	442,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,428,100.00	4,428,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,322,400.00	18,322,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,164,800.00	1,164,800.00
210302	Түлш, халаалт	17,157,600.00	17,157,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,649,300.00	8,649,300.00
210401	Бичиг хэрэг	2,247,600.00	2,248,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,089,000.00	5,088,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,224,700.00	1,224,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	88,000.00
2105	Нормативт зардал	457,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,902,100.00	6,902,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00
210602	Тавилга	743,500.00	743,500.00
210604	Урсгал засвар	3,158,600.00	3,158,600.00
2107	Томилолт, зочны зардал	2,739,800.00	2,739,800.00
210702	Дотоод албан томилолт	2,739,800.00	2,739,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй	1,302,800.00	1,302,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	150,400.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,200.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,900.00	178,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	398,700.00	398,700.00
210807	Газрын төлбөр	37,300.00	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	70,000.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,000,000.00	14,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,500,000.00	13,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,423,200.00	12,423,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,423,200.00	12,423,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,423,200.00	12,423,200.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	316,091,300.00	316,091,300.00

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	316,091,300.00	316,091,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	316,091,300.00	316,091,300.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	23.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24.0	23.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,367,822.00	1,538,580.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,367,822.00	1,538,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,367,822.00	1,538,580.00
2104	Хангамж, бараа материалын зардал	463,760.00	-
210402	Тээвэр, шатахуун	463,760.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,904,062.00	1,538,580.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,904,062.00	1,538,580.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1,538,580.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,538,580.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,538,580.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 3/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Төр захиргаа, нийгмийн бодлогын үйл ажиллагаа, төрийн албыг хууль тогтоомжийн хүрээнд зарчмын дагуу тасралтгүй явуулах зорилго дэвшүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 322.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.9 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	120.0	0.00	-120.0
Авлага	880.7	2098.7	1218.0
Урьдчилгаа	0.00	0.00	0.0
Бараа материал	937.9	2011.8	1073.9
Үндсэн хөрөнгө	620507.6	636309.2	15801.6
Нийт хөрөнгө	622446.2	640419.7	17973.5
Өр төлбөр	11800.4	2284.8	-9515.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	610645.8	638134.9	27489.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	622446.2	640419.7	17973.5

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлтэй гарсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 2.0 сая төгрөг болж 1.2 сая төгрөгөөр өссөн нь ажиллагсдын авсан цалингийн урьдчилгаатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.0 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 33.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 32.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 636.3 сая төгрөг болж 15.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 6.3 сая төгрөгийн, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 43.6 сая, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 9.9 сая төгрөгийн

хөрөнгийг тус тус орлого авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 70 дугаар тогтоол, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 29 дугаар тогтоолоор 24.3 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2.2 сая төгрөг болж 9.5 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой татварын болон тээвэр шатахууны өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 638.1 сая төгрөг болж 27.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 371.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 98 сая төгрөгөөр 20.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилт, нэмэлт болон хөрөнгийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 20.7 сая төгрөгөөр буюу 6.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна.

Нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, албан томилолт, зочны зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг өмнөх оноос нэмэгдэж, цалингийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, урсгал засварын зардал, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны анх батлагдсан төсөв 298.8 сая төгрөг, тодотгосон төсөв 316.0 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталснаас 17.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

Эд хогшил, урсгал засварыг 5.7 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 11.5 төгрөгөөр нэмж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 316.0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 316.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт төсвийн 70.0 хувийг цалин, 9.4 хувийг НДШ-ийн зардал, 5.8 хувийг тогтмол зардал, 2.7 хувийг хангамж бараа материалын зардал, 2.2 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 4.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.9 хувийг урсгал шилжүүлэг 1.6 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас төсөл хэрэгжүүлэхээр 1.5 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын нийт санхүүжилт 316.0 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 282.0 сая төгрөгийн зардлыг хасахад 34.0 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 3.4 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж ажиллаагүй, байгууллагын даргын тушаалаар ажиллагсад шинэ жилийн арга хэмжээнд зориулан 500.0 мянган төгрөгийн гарын бэлгийг олгосоноос үзэхэд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд нийт 371.2 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 371.2 сая төгрөгийн 148 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроосон, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар санхүүгийн тайланд цалин тооцож олгохдоо холбоотой 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 11.8 сая төгрөгийн өр төлбөр, жолоочийн шатахуун зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийн тооцоог хийгээгүй, Шилэн дансны 6 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Шатахуун зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийн тооцооноос бусад зөрчлүүдийг арилгаж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан түүвэрлэн шалгасан тул, цалингийн зардал, тээвэр шатахууны зарцуулалтыг гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 6.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Тайланд онд зарцуулсан 2150.0 мянган төгрөгийн тээвэр шатахууны зарцуулалтын баримтын бүрдэлт дутуу, нярвын бараа материалын зарцуулалтын тайлан, нягтлан бодогчийн гаргасан бараа материалын тайлангаас 232.4 мянган төгрөгөөр зөрүүтэй, шатахууны зарцуулалтын жагсаалтад хэрэглэсэн албан тушаалтнуудаар гарын үсэг зуруулж баримтжуулаагүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт болон нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

1. Баяннуур сумын Засаг даргын Тамгын газар нь 316091.3 мянган төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж гүйцэтгэлээр 316091.3 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 34051.0 мянган төгрөгийн төсвийн 10 хувь 3405.1 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, байгууллагын даргын тушаалаар ажиллагсад шинэ жилийн арга хэмжээнд зориулан 500.0 мянган төгрөгийн гарын бэлгийг олгож тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.6-т "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалт болон нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Байхгүй.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баяннуур сумын ЗДТГ	2	6.2					2	6.2		